

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/05

Улаанбаатар хот

Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/01 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ–ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ–ийн 2021 оны 02 дугаар сарын 05–ны өдрийн 21/02 тоот тогтоолоор батлагдсан “Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлого”–д энэхүү тогтоолын хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
2. Энэхүү тогтоолын 1–т заасан бодлогод орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг Компанийн дэргэдэх ТУЗ–ийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д үүрэг болгосугай.
3. Энэхүү нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, пэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ–д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ–ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга (Б.Итгэл)–д даалгасугай.



О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/06

Улаанбаатар хот

**Эрсдэлийн удирдлагын бодлогод
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.17 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)–ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлын 23/02 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ–ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ–ийн 2021 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн 21/46 тоот тогтоолоор батлагдсан “Эрсдэлийн удирдлагын бодлого”–д энэхүү тогтоолын хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
2. Компанийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”, түүнд орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлж ажиллах, гүйцэтгэлийг Компанийн дэргэдэх ТУЗ–ийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д үүрэг болгосугай.
3. Компанийн “Эрсдэлийн удирдлагын бодлого”–д нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбогдуулан Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх холбогдох бусад бодлого, дүрэм, журам, зааврыг түүнд нийцүүлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд өөрчлөлтийн саналыг Компанийн ТУЗ–д танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)–д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Компанийн ТУЗ–ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны дарга (Б.Итгэл)–д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/08

Улаанбаатар хот

**Компанийн 2022 оны санхүүгийн
тайлангийн талаар дүгнэлт батлах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 80 дугаар зүйл, 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/01 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд Монгол Улсын Аудитын тухай хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийн ажилласан “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК-ийн гаргасан аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих эрх бүхий байгууллагуудад хүргүүлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Компанийн гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга (Ж.Жаргалсүрэн)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/09

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн Үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.8 дахь заалт, Компанийн Ногдол ашгийн бодлогын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, болон Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.75 (нэг зууны далан тав) төгрөгөөр тогтоож, 2022 оны цэвэр ашгийн 23.4 (хорин гурав аравны дөрөв) хувийг буюу 1,293,778,000 (нэг тэрбум хоёр зуун ерэн гурван сая долоон зуун далан найман мянга) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөртэй нэгэн ижил байхаар тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төл” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 04 дүгээр сарын 30-ны дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, Компанийн ТУЗ-өөс Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай шийдвэр гармагц ногдол ашиг авах эрхтэй Компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг хувьцаа эзэмшигчдэд жич мэдээлэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/10

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө, төсвийн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/11

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 заалт, 80 дугаар зүй, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дахь заалт, Компанийн Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын 6 дугаар зүйлийн 6.8, 6.12 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ГУЗ”)-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/03 тоот дүгнэлт болон Компанийн ГУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд өрийн бичиг гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, бусад арилжааны эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээндээс давсан болон хоёрдогч эх үүсвэрийн санал, Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу Компанийн ГУЗ-өөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Компанийн ГУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/12

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлын 2022 оны
гүйцэтгэлийн үр дүнг батлах тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 81 дугаар зүйлийн 81.5.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.9 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/01 тоот дүгнэлт, Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ний өдрийн 22/31 тоот тогтоол болон Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2022 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлантай холбогдуулан Б.Удвалын 2022 оны үр дүнгийн урамшууллыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын хавсралтад заасан гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллыг тооцон Б.Удвалд нэг удаа олгох, ийнхүү олгохдоо холбогдох хууль тогтоомжид заасан татвар, шимтгэлийг суутгахыг Компанийн Ерөнхий нягтлан бодогч (Г.Золжаргал)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

№ 23/13

Улаанбаатар хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.7 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.20 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг болон Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “АНД Системс” ХХК-тай байгуулсан “Менежментийн үйлчилгээний гэрээ”-ний дагуу “АНД Системс” ХХК-аас үзүүлж буй үйлчилгээний цар хүрээ нэмэгдсэнтэй холбогдуулан тус гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсүгэй.
2. “Менежментийн үйлчилгээний гэрээ”-д оруулах нэмэлт, өөрчлөлтийн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталж, түүнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

